

**МӨРӨН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ЖАМСРАНЖАВЫН  
ЭРДЭНЭЦЭЦЭГИЙН  
ДЭВШҮҮЛЖ БУЙ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020.07.22.

ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ 2020.

МӨРӨН СУМ

 5500001

Мөрөн сумын ИТХ-д бие даан нэр дэвшигч Ж.Эрдэнэцэцэг Мөрийн хөтөлбөр

**Уриа: Хөвсгөлийн ард иргэд бид  
Хөгжсөн Хөвсгөлд, шударгаар амьдрах эрхээ эдлэнэ.**

### **ҮНДЭСЛЭЛ**

Монгол Улсын иргэн бүр Үндсэн хуулиар олгогдсон “Сонгох, сонгогдох эрх”-ийн дагуу Монгол Улсын иргэн Жамсранжав овогтой Эрдэнэцэцэг миний бие Хөвсгөл аймгийн ИТХ-ыг сонгох “Орон нутгийн сонгууль 2020”-д Бие даан нэр дэвшин, дараахь мөрийн хөтөлбөрөөр өөрийн байр суурийг илэрхийлэн оролцож, сонгуульд өрсөлдөнө.

### **НЭГ. “ҮНДЭСНИЙ ӨВ СОЁЛ, ТҮҮХ УЛАМЖЛАЛ”-ЫГ ХАМГААЛНА.**

Монголын уламжлалт ёс заншил, түүхэн уламжлал, эх оронч үзэл баримтлал, онгон дагшин байгаль, эх нутгаа хайрлан хамгаалахад ард түмний дуу хоолой нь болон ажиллана.

- 1.1. Эх орон, тусгаар тогтнол, зан заншил, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, хамгаалахад хуулиа дээдлэн хэрэгжүүлэхийн төлөө холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 1.2. Нутаг орныхоо унаган төрх байдлыг хамгаалахын төлөө тууштай тэмцэнэ.
- 1.3. Нутаг усныхаа цөлжилт, бэлчээрийн доройтол, хөрсний бохирдолын эсрэг усны нөөцийг хамгаалахын төлөө төрийн бодлогыг хандуулахад түмний дуу хоолой нь болон ажиллана.

### **ХОЁР. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, ШУДАРГА ЁСНЫ ТӨЛӨӨ ИРГЭДИЙН ДУУ ХООЛОЙГ ХАМГААЛАН АЖИЛЛАНА.**

Хүний эрх чөлөөг дээдлэн хамгаалж, хууль ёсыг иргэн бүрт тэгш хүртээмжтэй хүргэж, ард түмнийхээ эрх ашгийг хамгаалсан хуулийн засаглалын төлөө иргэдийн дуу хоолой нь болж ажиллана.

2.1. Иргэддээ цаг хугацаа алдалгүй үйлчилдэг төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэдэг туршлагауудыг нэвтрүүлэн “Иргэнээ дээдэлсэн” үйлчилгээг дэмжин, хамтран ажиллана.

2.2. Төрийн албан хаагч бүр хуулиа дээдлэн, алдаа гаргасан тохиолдолд олон нийтийн хүсэл сонирхолд нийцүүлэн хариуцлага тооцдог механизмыг боловсронгуй болгох санаа санаачилгыг дэмжин, хамтарч ажиллана.

2.3. Төрийн албаны МЕРАТ зарчмыг баримтлан, тогтворжуулахын төлөө шударгаар ажиллана.

2.4. Иргэндээ үйлчилдэг Төрийн үйлчилгээг бүх шатанд нь дээдэлхийн төлөө тууштай ажиллана.

2.5. Иргэнээ сондог, Иргэнээ хүндэлдэг, Иргэнийхээ асуудалыг шийдвэрлэхийн төлөө тууштай арга хэмжээ авч ажиллана.

### **ГУРАВ. ЭРҮҮЛ ИРГЭН, ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ АЖИЛЛАНА.**

Мөрөн сумын ИТХ-д бие даан нэр дэвшигч Ж.Эрдэнэцэцэг Мөрийн хөтөлбөр

Монгол улсын Үндсэн хуулиар олгогдсон” Монгол хүн эрүүл, саруул, айх аюулгүй, амгалан тайван амьдралын төлөө” эрхийг эдлүүлэхийн тулд ард түмний дуу хослой нь болон ажиллана.

3.1. Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг, гарч болзошгүй гэмт хэргийн эсрэг холбогдох байгууллагуудтай хамтран тууштай ажиллана.

3.2. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгааг хангахын төлөө Хөршийн холбоог бэхжүүлэх санаа, санаачилгыг гарган ажиллана.

3.3 Иргэдийг эрүүл саруул хөдөлмөрлөхөд стандарт норм, дүрмийг баримтлан ажиллахын төлөө байгууллага, ААН, ХХК, хувь хүнтэй хамтран ажиллахыг эрхэмлэнэ.

3.4. Өрх толгойлсон эмэгтэйчүүд болон Хүүхэд хамгаалалын асуудалыг дэмжин, тулгамдсан асуудалыг шийдвэрлүүлэхийн төлөө санал санаачилга гаргаж ажиллана.

3.5. Хүүхэд, залуучуудын амралт, чөлөөт цаг, сурч боловсрох нөхцөл боломжийг байнга анхааран ажиллахын зэрэгцээ Төрийн болон ТББ-тай хамтран ажиллаж, үйл ажиллагаанд нь хөндлөнгийн хяналт тавьж ажиллуулахын төлөө санаачилга гаргана.

3.6. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэн бүрт хүртээмжтэй хүргэхийн төлөө хамтран ажиллана.

#### **ДӨРӨВ. ОРЛОГОТОЙ, САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭРТЭЙ - ӨРХ, ИРГЭН БҮРИЙН ОРОЛЦООГ ХАНГАХЫН ТӨЛӨӨ АЖИЛЛАНА.**

Өрхийн ядууралыг бууруулахын тулд өрх бүр, иргэн бүр үйлдвэрлэгч, орлоготой байх нөхцөл боломжийг ханган ажиллана.

4.1. Нийгмийн баялагийг бүтээхэд иргэн бүрийн оролцоог эн тэнцүү хангахын зэрэгцээ өөгөөд тэгш шударгаар хувиарлах ил тод, хяналттай, хариуцлагатай тогтолцоог хэрэгжүүлэхийн төлөө бодлогыг хэрэгжүүлэнэ.

4.2. Жижиг дунд үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрт иргэд, өрх гэрийг хамруулахын төлөө шударгаар ажиллана.

4.3. Орон нутагт түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн болгон зах зээлд нийлүүлэхэд анхаарч, төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажиллана.

Эцсийн үр дүнд: Хөвсгөлчүүдийн төлөө, иргэн хүний төлөө, ард түмнээ амар тайван аз жаргалтай амьдруулахын төлөө, эх орныхоо төлөө чин сэтгэлээсээ иргэн бүртэйгээ хамтран ажиллахад Хөгжсөн Хөвсгөлд шударгаар амьдарч болдогийг харуулж, хамтран амьдарна.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ - *Ж*  
.....ЖАМСРАНЖАБЫН ЭРДЭНЭЦЭЦЭГ.

*Жамсранжабын Эрдэнэцэцэг*

*Д. Мавсүрэн*

